



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН

# ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

## Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.“Нэр дэвшигч” гэж сонгон шалгаруулалтад хүсэлтээ ирүүлсэн иргэнийг хэлнэ.

1.3.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарсан тоогоор зарлаж, энэ журмын дагуу нэр дэвшүүлнэ.

1.4.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална.

- 1.4.1.хууль дээдлэх;
- 1.4.2.шударга ёсыг баримтлах;
- 1.4.3.аливаа нөлөөллөөс ангид, хараат бус байх;
- 1.4.4.төвийг сахих;
- 1.4.5.бодитой хандах;
- 1.4.6.нээлттэй, ил тод байх;
- 1.4.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

1.5.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг Төсвийн байнгын хороо /Байнгын хороо/- ноос байгуулсан Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ зохион байгуулна.

1.6.Ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг Байнгын хороо хангах бөгөөд Байнгын хорооны ажлын алба, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ. Энэ журамд заасны дагуу холбогдох баримт бичиг, зар, бусад мэдээллийг цахим хуудаст байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх, нийтэд мэдээлэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох нэгж техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

1.7.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа энэ журмын 1.4-т заасан зарчмыг баримтлах ба хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

1.8.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өндөржүүлсэн, эсхүл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажлын хэсгийн хуралдааныг цахимаар зохион байгуулах асуудлыг Ажлын хэсэг шийдвэрлэж болно.

1.9.Энэ журмыг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудас /www.parliament.mn/-д хавсралтын хамт байршуулна.

**Хоёр.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд  
нэр дэвшигчид тавих шаардлага**

2.1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна:

2.1.1.эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

2.1.2.сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх;

2.1.3.зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш 6 жилийн хугацаанд аливаа сонгуульд нэр дэвшихгүй байх;

2.1.4.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;

2.1.5.хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

2.1.6.эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.

### **Гурав.Сонгон шалгаруулалтын үе шат**

3.1.Сонгон шалгаруулалтыг 45 хоногийн хугацаанд дараах үе шаттай зохион байгуулна:

3.1.1.ажлын хэсэг байгуулах;

3.1.2.сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх;

3.1.3.нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авах;

3.1.4.нэр дэвшигчийн мэдээллийг байршуулах;

3.1.5.ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах;

3.1.6.нэр дэвшигч бүрээр үнэлгээ өгч, сонгон шалгаруулалтын дүнг гаргах;

3.1.7.хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийг Төсвийн байнгын хороонд санал болгох.

### **Дөрөв.Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх**

4.1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй хэлбэрээр давтамжтай мэдээлнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан зард нэр дэвших тухай хүсэлт ирүүлэх хугацаа, баримт бичиг хүлээн авах хаяг, цахим шуудангийн хаяг, лавлах утасны дугаар, энэ журмын 2.1-д заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, энэ журмын 5.1-д заасны дагуу бүрдүүлэх бичиг баримтыг заана.

## **Тав. Нэр дэвших тухай хүсэлт гаргах**

5.1.Энэ журмын 4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших хүсэлтэй этгээд нь дараах баримт бичгийг Байнгын хороонд ирүүлнэ:

5.1.1.нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар, түүнчлэн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг хүсэлтэд бичнэ/;

5.1.3.төрийн албан хаагчийн анкет;

5.1.4.иргэний үнэмлэхний хуулбар;

5.1.5.нийгмийн даатгалын дэвтэр /хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа; /e-mongolia–аас татан авах/;

5.1.6.бакалавр, магистр болон түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар /хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;

5.1.7.хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт бөглөх (нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягтыг татан авч бөглөж хавсаргах);

5.1.8.эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах онцлох 10 үйл ажиллагааны талаарх баримт;

5.1.9.холбогдох бусад бичиг баримт;

5.2.Энэ журмын 5.1.1-д заасан нэр дэвших хүсэлтийг Байнгын хорооноос баталсан загварын дагуу гаргаж, холбогдох бүх мэдээллийг бүрэн, үнэн зөв өгнө.

5.3.Байнгын хорооны ажлын алба нь нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, бусад баримтын үнэн зөв байдлыг шалгах зорилгоор хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулган үзэж, шаардлагатай эх лавлагааг авч болно.

## **Зургаа.Ажлын хэсгийн чиг үүрэг, хориглох зүйл**

6.1.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авах, бүрдлийг хянах;

6.1.2.нэр дэвшигч хуульд заасан холбогдох шаардлагыг хангасан эсэхийг хянах, гишүүн бүрийн өгсөн үнэлгээг нэгтгэн, санал дүгнэлт гаргах;

6.1.3.сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хянан, шийдвэрлэх;

6.1.4.сонгон шалгаруулалтын үйл явц, дүнг нийтэд мэдээлэх;

6.1.5.сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж сонгон шалгаруулалтын үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан иргэнийг зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж томилох саналаа Байнгын хороонд хүргүүлэх;

6.1.6.сонгон шалгаруулалтын бичиг баримтыг зохих журмын дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын архивд хүлээлгэн өгөх.

6.2.Ажлын хэсгийн гишүүнд дараах зүйлийг хориглоно:

6.2.1.нэр дэвшигчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч дүү байх;

6.2.2.ажлын хэсгийн гишүүн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах;

6.2.3.хүсэлт гаргагч, нэр дэвшигчийг ялгаварлан гадуурхах;

6.2.4.сонгон шалгаруулалтад итгэх итгэлийг унагаж зохисгүй байдал гаргах;

6.2.5.ажлын хэсгийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг, шан харамж авах;

6.2.6.ажлын хэсгийн гишүүний хувиар нэр дэвшигч нарын талаар урьдчилан дүгнэлт хийж олон нийтэд мэдээлэх;

6.2.7.ажлын хэсгийн гишүүний нэр хүндийг урвуулан ашиглах.

6.3.Ажлын хэсгийн гишүүнд энэ журмын 6.2.1-д заасан нөхцөл үүссэн бол сонгон шалгаруулах ажиллагаанаас татгалзан гарна.

6.4.Ажлын хэсгийн гишүүн энэ журамд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нээлттэй сануулна.

6.5.Ажлын хэсгийн гишүүн энэ журмын 1.4, 6.2-т заасныг зөрчсөн нь тогтоогдсон бол Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс хасна.

6.6.Ажлын хэсгийн хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон энэ журамд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

#### **Долоо.Нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, олон нийтэд мэдээлэх**

7.1.Бүртгэл хааснаас хойш ажлын хоёр хоногийн дотор оролцогчдын нэрс болон бусад мэдээллийг [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудаст байрлуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

7.2.Энэ журмын 7.1-д заасны дагуу байршуулах баримт бичиг, мэдээллээс гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хасна.

## **Найм.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх**

8.1.Ажлын хэсэг нь дараах ажиллагаа явуулж мэдээлэл бүрдүүлнэ:

8.1.1.ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг судлах, үнэн зөвийг нягтлах;

8.1.2.хэвлүүлсэн бүтээл /ном, өгүүлэл, тайлан зэрэг/ болон олон нийтэд өгсөн мэдээллийг судалж, дүгнэх;

8.1.3.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулан авах;

8.1.4.нэр дэвшигчтэй ярилцлага хийх, түүнээс нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;

8.1.5.нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулах.

8.2.Ажлын хэсэг энэ журамд заасны дагуу нэр дэвшигчтэй ярилцлага хийхдээ биечлэн, цахим эсвэл бусад хэлбэрийг ашиглаж болох бөгөөд ярилцлагын огноо, цаг хугацаа, гол агуулгын тухай тэмдэглэл үйлдэнэ.

8.3.Ажлын хэсэг нэр дэвшигчийн талаар бүрдүүлсэн мэдээлэлд сөрөг агуулга байвал тухайн нэр дэвшигчид танилцуулж тайлбар өгөх боломжоор хангах бөгөөд тухайн мэдээллийг итгэмжлэн өгсөн хүний нэр эсхүл түүнийг таних шинжийн талаар нэр дэвшигчид мэдэгдэхийг хориглоно.

8.4.Байнгын хорооны ажлын албанд нэр дэвшигчийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтийн байгууллагаас ирүүлсэн бол ажлын хэсэгт тухай бүр танилцуулна.

8.5.Нэр дэвшигч энэ журмын 2 дахь заалтад заасан шаардлагыг хангасан тухай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ажлын хэсэгт гаргаж өгч болно.

8.6.Нэр дэвшигчийн талаарх лавлагаа авах, нэмэлт мэдээлэл, баримт, тайлбар гаргуулах зэрэг ажиллагааг Ажлын хэсгийн ахлагч өөрийн санаачлагаар эсхүл ажлын хэсгийн гишүүний хүсэлтийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулж болно.

### **Ес.Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах**

9.1.Нэр дэвших тухай хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 13 өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.

9.2.Нэр дэвшигч ярилцлагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол бүртгэлээс хасах үндэслэл болно.

9.3.Ажлын хэсгийн гишүүд ярилцлагын үеэр энэ журмын 2 дахь заалтад заасан шаардлага, нэр дэвших тухай хүсэлтэд үндэслэсэн асуултыг оролцогчоос асууж, хариулт авна. Ялгаварлан гадуурхсан эсхүл доромжилсон асуулт асуухыг хориглоно.

9.4.Ажлын хэсэг ярилцлага хийхдээ ажлын хэсгийн гишүүн бүр нэр дэвшигчийн үнэлгээний хуудас /хавсралт 1/-ыг бөглөнө.

### **Арав.Нэр дэвшигчийг санал болгох**

10.1.Нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 13 хоногийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэнэ:

10.1.1.нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, ажлын хэсгийн ярилцлагын дүнд үндэслэн нэр дэвшигч энэ журмын 2 дахь заалтад заасан шаардлага тус бүрийг хэрхэн хангаж байгаа талаар Ажлын хэсгийн гишүүн бүр санал өгч, зөвлөлдөнө. Ажлын хэсэг нэр дэвшигчийг үнэлэхэд нотолгоогүй мэдээллийг ашиглахгүй;

10.1.2.ажлын хэсгийн гишүүн тус бүр нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, Ажлын хэсгийн ярилцлагын дүнг үнэлсний үндсэн дээр нэр дэвшигчийг үнэлэх үнэлгээний хуудсыг бөглөж өгнө.

10.2.Ажлын хэсгийн үнэлгээний нийт дүнгээр хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийг онооны дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон шаардлагатай бол дараагийн өндөр оноо авсан хоёр хүртэл хүний хамт зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, томилох саналаа Байнгын хороонд хүргүүлнэ.

10.3.Эхний үнэлгээгээр тухайн орон тоонд нэр дэвшигчид оноо тэнцсэн бол Байнгын хороонд уг оноо тэнцсэн нэр дэвшигч нарын нэрийг хамтад нь хүргүүлнэ.

10.4. Нэр дэвших тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.

10.5.Ажлын хэсгийн хурал, түүний тэмдэглэл, ажлын хэсгийн гишүүний нэр дэвшигчийг үнэлсэн үнэлгээний хуудас зэрэг нь албаны нууцад хамаарах бөгөөд холбогдох хууль тогтоомжоор хамгаалагдана.

Үнэлгээний хуудасны дугаар ...

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД  
НЭР ДЭВШИГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Нэр дэвшигчийн дугаар: .....

Нэр дэвшигчийн нэр: .....

**Үнэлгээний I хэсэг:**

#	Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх шалгуур	Үнэлгээ	Тэмдэглэгээ	Тайлбар /Тэмдэглэгээ хийсэн үндэслэл/
1	Сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх	Тийм/Үгүй		
2	Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш 6 жилийн хугацаанд аливаа сонгуульд нэр дэвшихгүй байх	Тийм/Үгүй		
3	Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх	Тийм/Үгүй		
4	Хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх	Тийм/Үгүй		
5	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх	Тийм/Үгүй		
6	Бурдуулэх материалын иж бүрдэл гүйцэд байх	Тийм/Үгүй		
7	Тавигдах шаардлагыг бүрэн хангасан эсэх	Тийм/Үгүй		

**Үнэлгээний II хэсэг:**

#	Үнэлэх шалгуур үзүүлэлт	Дээд үнэлгээ	Үнэлгээ	Тайлбар /Үнэлгээ өгсөн үндэслэл/
1	Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	10		
2	Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	15		
3	Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэл	5		
4	Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл	10		
5	Хүсэлт гаргагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагаа	15		
6	Ут албан тушаалд нэр дэвшсэн үндэслэл	5		
7	Зөвлөлийн гишүүнээр томилогдвол хийх ажил	10		
8	Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага:			
	A. Улс орны хөгжлийн бодлого болон төсвийн уялдааг хангах талаарх үзэл бодол	10		
	B. Нэр дэвшигчийн ирүүлсэн материал болон бодит байдлын нийцэл	10		
	C. Олон нийтэд байр сууриа таниулах, илэрхийлэх чадвар	10		
<b>Нийт</b>		<b>100</b>	<b>0</b>	

**Үнэлгээний III хэсэг:**

#	Үнэлгээнээс хасагдах үзүүлэлт	Дээд үнэлгээ	Үнэлгээ	Тайлбар /Үнэлгээ өгсөн үндэслэл/
1	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан	-10		
2	Сахилгын шийтгэл авч байсан	-10		
<b>Нийт</b>		<b>-20</b>		

**Үнэлгээний нийлбэр оноо:**

#	Үнэлгээний хэсэг	Дээд үнэлгээ	Үнэлгээ	Тайлбар /Үнэлгээ өгсөн үндэслэл/
1	Үнэлгээний II хэсэг буюу шалгуур үзүүлэлтээс авсан нийлбэр оноо	100	0	
2	Үнэлгээний III хэсэг буюу үнэлгээнээс хасагдах нийлбэр оноо	0	0	
<b>Нийт</b>		<b>100</b>	<b>0</b>	

Ажлын хэсгийн гишүүний нэр: .....

Ажлын хэсгийн гишүүний гарын үсэг: .....

Үнэлгээ нийсэн огноо: